



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141

Аудитын мөнөжер:
Утас: 70332860

Ахлах аудитор:
Утас: 70333019

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Цэцэрлэг хот
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2016 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,
хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус запруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Архангай аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд **Цагдаагийн газрын** төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /АРА-2016/20/САГ-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цагдаагийн газрын төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагдаагийн газрын 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2016 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Архангай аудитын газрын ахлах аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 21-нд Архангай аудитын газарт ирүүлсэн байна.

Архангай аудитын газар аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2016 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цагдаагийн газрын төсвийн захирагч нь Монгол улсын "Төсвийн тухай", "Цагдаагийн албаны тухай хууль" хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол

хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль хуулийн 1 дүгээр зүйлд хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүрэгтэй Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу. Цагдаагийн газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Тус байгууллагын 2015 оны төсвийг Архангай аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дун:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгур болгон ашиглав.

Аудитаар Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтий томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад **Цагдаагийн газрын** санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 800.5.14 а-д з аасан “*төсөө, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болосруулах*” журмын дагуу НБББ-ын баримт бичгийг батлан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013-02-15-ны өдрийн №113 тоот тушаалаар батлуулан 2013 оны 2 дүгээр сарын 15-нээс эхлэн мөрдэн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаатай ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуултаа явуулах аргаар танилцсан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн acolous програмаар боловсруулан санхүүгийн бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлан гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланда материалаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материалаг алдаа гараахас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. **Цагдаагийн газрын** дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүкуулснаас гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цагдаагийн газрын төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 1634.1 сая төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтээр 11.3 сая авч, 50.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгээс 66.6 сая төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 1711.2 сая төгрөг батлагдсанаас 1683.9 төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 27.3 сая төгрөгөөр хэмнэсэн мэт байгаа боловч түүний 10.4 сая төгрөг нь зарцуулах эрх олгоогүй дутуу санхүүжилт байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2015 оноос эхлэн нэгдсэн цахим хуудсанд оруулж эхэлсэн. Тус байгууллагын 2015 оны шилэн дансны мэдээллийг шалгахад хуульд мэдээлэхээр заасан мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт 23, хяналтын 14 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 15 нарийвчилсан горим, сорилт гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илрэхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланда нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал болон цалин, ндш, тогтмол зардуудын дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилтын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа илрээгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цагдаагийн газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Цагдаагийн газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланда Архангай аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материалыг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, хавсралтуудыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР  Т.БАЙГАЛМАА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.УЛАМБАЯР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  Н.АЛТАНТУЯА

2016.02.24